

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/9/НА-СТА-ОНТС

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	8
3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	8
3.5.1 Төсвийн төлөвлөлт	8
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	9
3.5.3 Нэмэлт төсөв	9
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	9
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	9
4.1 Ерөнхий зүйл	9
4.2 Материаллаг байдал	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
4.5.1 Завсрын аудитын талаар	10
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	10
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
5.1 Төлбөрийн акт	11
5.2 Албан шаардлага	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059.
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2021.02.25 № 86

танай _____ -нд № _____ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН
СУМЫН ЗАСАГ ДАРГА Б ТҮМЭНЦОГТ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоог хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд зээлийн гэрээгүй 5,682.2 мянган төгрөгийн 14 зээлдэгчийн, 2011-2021 онд олгосон 29,517.2 төгрөгийн 9 зээлдэгчийн хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй зээлд нэмэгдүүлсэн хүү, алданги тооцоогүй, зээлдэгчтэй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, мөн 2022 онд олгосон 3 зээлийн эргэн төлөх хугацаа хоцорсон, төлөгдөөгүй зээлийн дүн гэрээний дүнгээс 31,090.2 мянган төгрөгөөр илүү тусгасан зэрэг нийт 66,289.6 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон 2,818.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 тушаалын 3 дугаар зүйлийн 3.4.3-т "Төслийг хэрэгжүүлэх этгээдтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавих", 6 дугаар зүйлийн 6.9-д "Хуулийн этгээд иргэн нь авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө", 6.10-т "Сумын Засаг

4520050198

дарга зээлдэгчийн талаарх дараах баримт бичгийг эх хувиар нь баримтжуулан хадгална", 6.10.6-д Зээлийн болон барьцааны гэрээ", 10 дугаар зүйлийн 10.1-д "Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина", 10.4-т "Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чанаргүй активын ангилалд оруулж, Монгол банкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "Нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд нийт 122,280.0 мянган төгрөгийн зээл шинээр олгож, 48,244.8 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоог хөгжүүлэх сан нь 2025 онд 7 зорилт 42 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 95.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	270,759,260.43	285,764,131.74
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	84,895,878.70	14,644,873.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	84,895,878.70	14,644,873.00
31211	Төрийн сангийн харилцах	84,895,878.70	14,644,873.00
33	АВЛАГА	183,266,890.73	268,522,767.74
33400	Зээлийн хүүгийн авлага	8,986,492.32	20,607,131.99
335	Бусад авлага	174,280,398.41	125,635,635.75
33510	Байгууллагаас авах авлага	400,000.00	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	173,880,398.41	125,635,635.75
336	Зээлийн авлага	-	122,280,000.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	-	122,280,000.00
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	-	122,280,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,596,491.00	2,596,491.00
354	Хангамжийн материал	2,596,491.00	2,596,491.00
35410	Бичиг хэргийн материал	2,596,491.00	2,596,491.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	750,000.00	600,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	750,000.00	600,000.00
393	Биет бус хөрөнгө	750,000.00	600,000.00
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(150,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	271,509,260.43	286,364,131.74
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	94,000.00	287,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	94,000.00	287,000.00
413	Өглөг	94,000.00	287,000.00
4136	Бусад өглөг	94,000.00	287,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	94,000.00	287,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	271,415,260.43	286,077,131.74
51	Засгийн газрын хувь оролцоо	271,415,260.43	286,077,131.74
512	Хуримтлагдсан үр дүн	271,415,260.43	286,077,131.74
51210	Өмнөх үеийн үр дүн	271,415,260.43	271,415,260.43
51220	Тайлант үеийн үр дүн	-	14,661,871.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	271,509,260.43	286,364,131.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,990,405.31	15,719,871.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,990,405.31	15,719,871.31
120	Нийтлэг татварын бус орлого	7,990,405.31	15,719,871.31
120002	Хүүгийн орлого	7,240,405.31	15,719,871.31
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	750,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,496,800.00	1,058,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,496,800.00	1,058,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,496,800.00	1,058,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,496,800.00	908,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,496,800.00	908,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	150,000.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		150,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,493,605.31	14,661,871.31
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,493,605.31	14,661,871.31

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	67,021,914.00	52,743,994.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,021,914.00	52,743,994.30
120	Нийтлэг татварын бус орлого	67,021,914.00	52,743,994.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	67,021,914.00	52,743,994.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,021,914.00	52,743,994.30
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,402,800.00	715,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,402,800.00	715,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,402,800.00	715,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,402,800.00	715,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,402,800.00	715,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	65,619,114.00	52,028,994.30
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	58,000,000.00	122,280,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	58,000,000.00	122,280,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(58,000,000.00)	(122,280,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	7,619,114.00	(70,251,005.70)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	77,276,764.70	84,895,878.70
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	84,895,878.70	14,661,871.31

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/			
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл		264,921,655.12	264,921,655.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	264,921,655.12	264,921,655.12
Тайлант үеийн үр дүн	-	6,493,605.31	6,493,605.31
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	271,415,260.43	271,415,260.43
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	271,415,260.43	271,415,260.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	271,415,260.43	271,415,260.43
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			-
Тайлант үеийн үр дүн	-	14,661,871.31	14,661,871.31
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	286,077,131.74	286,077,131.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	84,895,878.70	84,895,878.70	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	140,903,400.00	122,995,000.00	17,908,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,083,300.00	715,000.00	11,368,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,083,300.00	715,000.00	11,368,300.00
2300	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	128,820,100.00	122,280,000.00	6,540,100.00
230001	Эргэж төлөгдөх зээл	128,820,100.00	122,280,000.00	6,540,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	57,500,000.00	52,743,994.30	4,756,005.70
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	57,500,000.00	52,743,994.30	4,756,005.70
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,500,000.00	52,743,994.30	4,756,005.70
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	14,644,873.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоог хөгжүүлэх сангийн зорилго: сум орон нутагт жижиг дунд үйлдвэрлэлийг бий болгох, хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрны тоог нэмэгдүүлэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал болон холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Орхон сумын хоршоог хөгжүүлэх сан нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Орхон сумын хоршоог хөгжүүлэх сан нь 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэлдэхүүнээр, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,854.9 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	84,895.9	14,644.9	-70,251.0
Авлага	183,266.9	268,522.8	85,255.9
Бараа материал	2,596.5	2,596.5	-
Үндсэн хөрөнгө	750.0	600.0	-150.0
Нийт хөрөнгө	271,509.3	286,364.1	14,854.9
Өр төлбөр	94.0	287.0	193.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	271,415.3	286,077.1	14,661.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	271,509.3	286,364.1	14,854.9

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл данс 70,251.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд сангаас зээл олгосноос шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 85,255.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд сангаас олгох зээлийн дүн нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 600,000.00 төгрөг болж өмнөх оноос 150,000.00 төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 57,500.00 мянган төгрөг, урьд оны

үлдэгдлээс 83,403.4 мянган төгрөг, нийт зарлагыг 140,903.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 57,500.00 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 84,895.9 мянган төгрөг, нийт зарлагыг 140,903.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тайлант онд зээлийн хүүгийн орлого 4,099.2 мянган төгрөг, зээлийн эргэн төлөлт 48,644.8 мянган төгрөг нийт 52,744.0 төгрөгийн санхүүжилт орж, зарлагын гүйцэтгэл 122,995.0 мянган төгрөг буюу 87.3 хувьтай зарцуулж, оны эцсийн үлдэгдэл 14,644.8 мянган төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
		140,903.4	122,995.0	17,908.4	87.3
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	12,083.3	715.0	11,368.3	5.9
2	83111- Сум хөгжүүлэх	128,820.1	122,280.0	6,540.1	94.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Орхон сумын Хоршоог хөгжүүлсэн сан нь сумын Засаг даргын дэргэдэх байгууллага бөгөөд орон тооны ажилтангүй, хариуцсан мэргэжилтнүүд тамгын газраас цалинждаг тул хоол унааны хөнгөлөлт олгодоггүй.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд төлөвлөгдсөн худалдан авах ажиллагаа байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоог хөгжүүлэх сан, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн аудитор Ч.Баярсайхан, аудиторын туслах Э.Тунгалагтамир нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хаан консалтинг аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Ганцэцэг, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоог хөгжүүлэх сан нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/18 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 140,903.4 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 2,818.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд улсын төсвөөс зарцуулаагүй үлдэгдэл 11,368.3 мянган төгрөг байгаа нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар тэвчиж болох зардлыг хэмнэх ажлын хүрээнд төсвийн байгууллагуудын санхүүжилт, зарцуулалтын эрхийг хязгаарлаж, гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийж, нийт 47,940.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, жилийн эцсийн аудитаар горим сорил хэрэгжүүлэхэд зөрчлийг арилгаагүй тул жилийн эцсийн аудитад шилжүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын олгосон зээлийн эргэн төлөлт гэрээнд заасан хугацаанд төлөгддөггүй, зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөлт хийдэггүйгээс хугацаа хоцролт ихтэй, зээлийн гэрээний иж бүрдэл дутуу байгааг дараагийн аудитаар дахин нягталж, анхаарах асуудалд оруулахаар шийдвэрлэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 66,289.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

1. Орхон сумын Хоршоог хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлан дахь зээлийн үлдэгдлийг зээлдэгчийн мэдээлэлтэй тулгахад зээлийн гэрээ байхгүйгээс хэзээ олгосон нь тодорхойгүй 14 зээлдэгчийн 5,682.2 мянган төгрөгийн, 2011-2021 онд олгосон 9 зээлдэгчийн 29,517.2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн нийт 35,199,386.12 төгрөгийн төлөгдөөгүй зээлд нэмэгдүүлсэн хүү, алданги тооцоогүй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д *"Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"*, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын 3 дугаар зүйлийн 3.4.3-т *"Төслийг хэрэгжүүлэх этгээдтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавих"*, 6 дугаар зүйлийн 6.9-д *"Хуулийн этгээд иргэн нь авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө"*, 6.10-т *"Сумын Засаг дарга зээлдэгчийн талаарх дараах баримт бичгийг эх хувиар нь баримтжуулан хадгална"*, 6.10.6-д *Зээлийн болон барьцааны гэрээ"*, 10 дугаар зүйлийн 10.1-д *"Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина"*, 10.4-т *"Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чанаргүй активын ангилалд оруулж, Монгол банкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэнэ"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
2. 2022 онд олгосон 3 зээлийн эргэн төлөх хугацаа хоцорсон, төлөгдөөгүй зээлийн дүн гэрээний дүнгээс 31,090.2 мянган төгрөгөөр илүү тусгасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д *"Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"*, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын 3 дугаар зүйлийн 3.4.3-т *"Төслийг хэрэгжүүлэх этгээдтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавих"*, 6 дугаар зүйлийн 6.9-д *"Хуулийн этгээд иргэн нь авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө"*, 10 дугаар зүйлийн 10.1-д *"Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина"*, 10.4-т *"Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чанаргүй активын*

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ангилалд оруулж, Монгол банкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Тайл бар
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Зээлийн гэрээ байхгүйгээс хэзээ олгосон нь тодорхойгүй 14 зээлдэгчийн 5,682.2 мянган төгрөгийн, 2011-2021 онд олгосон 9 зээлдэгчийн 29,517.2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн нийт 35,199,386.12 төгрөгийн төлөгдөөгүй зээлд нэмэгдүүлсэн хүү, алданги тооцоогүй тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй	1	35,199.3	-	-	1	35,199.3	-	-	-	-	
2022 онд олгосон 3 зээлийн эргэн төлөх хугацаа хоцорсон, төлөгдөөгүй зээлийн дүн гэрээний дүнгээс 31,090.2 мянган төгрөгөөр илүү тусгасан	1	31,090.2	-	-	1	31,090.2	-	-	-	-	
Дүн	2	66,289.6	-	-	2	66,289.6	-	-	-	-	-